

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-23</i>

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	3-23
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
08 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 48 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Мөнхбаясгалан;
Чөлөөтэй: М.Бадамсүрэн, Ц.Даваасүрэн;
Тасалсан: Д.Батбаяр, Д.Жаргалсайхан.

Нэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, С.Нацагдорж, ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитор Б.Идэрбалжинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Ерөнхий санхүүч Ц.Амгалан, Мал эмнэлгийн ерөнхий газрын Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Б.Алтансүх, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Д.Үүрийнтуяа, Г.Очирбат, Г.Лувсанжамц, Б.Пунсалмаа, Д.Энхтуяа нарын

тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 15 минут үргэлжилж, 22 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 77.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим,
15 цаг 48 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Жавхлан сайд баг, хамт олонтойгоо, ажлын хэсгийнхэнтэйгээ ороод ирлээ. Мааш их сайхан баяртай үйл явдал болж байна.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаан 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 15 цагаас Чингис хаан танхимд хуралдана гэж товлогдсон. Ингээд Байнгын хороодын хуралдаан бас давхцаж байгааг гишүүд зөвөөр ойлгоосой.

Ингээд Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны ирц 63,6 хувь бүрдсэн тул Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Гишүүдийн ирцийг та бүхэнд танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут гишүүн 4 дүгээр тойрог ирсэн байна. Сайнхүүгийн Ганбаатар 1 дүгээр тойрог ирсэн байна. Пүрэвжавын Ганзориг гишүүн ирсэн байна. Хажсекберийн Жангабыл гишүүн 3 дугаар тойрог ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн 9 дүгээр тойрог ирсэн байна. Сүрэнжавын Лүндэг 5 дугаар тойрог ирсэн байна. Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна. Бадамдоржийн Пунсалмаа ирсэн байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн ирсэн байна.

Буяагийн Тулга гишүүн 5 дугаар тойрог ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Доржсүрэнгийн Үүрийнтуяа 4 дүгээр тойрог ирсэн байна. Доржзовдын Энхтуяа ирсэн байна. Дашицэрэнгийн Энхтүвшин гишүүн ирсэн байна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн бас орж ирээд ирцэд орсон байна.

Ингээд ирц хангалттай байгаа учраас хуралдаанаа үргэлжлүүлье. Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газрын 2024 оны 08 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын ...

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байхгүй байгаа учраас хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг та бүхэнд танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Магнайсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жамбалцэрэн

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Сангийн яамыг төлөөлөөд Цогбадрах Төрийн сангийн газрын дарга, Босоод танилцуулаад байгаарай. С.Тулга Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Гантогтох Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Рэнцэнханд Төрийн сангийн төлбөр тооцооны хэлтсийн дарга,

Үндэсний Аудитын газраас Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч ирчихсэн байна. Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Энхтуяа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер ирсэн байна. С.Нацагдорж гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер ирсэн байна. Ч.Болд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, У.Оюунхүү Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Эрдэнэзул Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор ирсэн байна. С.Бат-Эрдэнэ Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Идэрбалжинням Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, Д.Нямжаргал Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор,

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас С.Сүхбат Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга, Б.Анхбаяр Газрын тосны бодлогын газрын дарга, Х.Санчигдорж Геологийн бодлогын газрын дарга, М.Мэндбаяр Уул уурхайн бодлогын газрын дарга, Б.Отгонцэцэг Санхүүгийн хэлтсийн дарга,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Л.Идэрцогт Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ц.Амгалан Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Ерөнхий санхүүч, Б.Алтансүх Мал эмнэлгийн ерөнхий газрын Төрийн захиргаа удирдлагын газрын дарга,

Я.Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын дарга.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулчихлаа.

Одоо Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн талаар Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Баярлалаа. Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 08 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг танилцуулсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2023 онд 23,3 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22,5 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2,2 их наяд төгрөгийн алдагдалтай төлөвлөгдсөнөөс 785,9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан ба сүүлийн жилүүдэд дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Хүнс, хөдөө аж хуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын нийт 91 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн

ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 402 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, үүнээс урсгал зардалд 290 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 95 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 90 хувь буюу 363,7 тэрбум төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, 9,7 хувь буюу 38,9 тэрбум төгрөгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын зарлага эзэлж байна.

Улсын төсвөөс 379,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 59 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, та бүхэн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Ганбаатар: Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна.

Д.Загджав: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын

хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

Барилга, хот хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 37 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 27 байгууллага дүгнэлт гарган, 10 байгууллагын аудитын түүвэрт хамруулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай харьяа 22 байгууллагад өөрчлөлтгүй, 5 байгууллагад хязгаарлалтын дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар 151,6 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0,2 тэрбум төгрөгийн зөрчил, 29 төлбөрийн акт тогтоож 147,5 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, 37 албан шаардлага хүргүүлж, 2,7 тэрбум төгрөгийн зөрчилд 44 зөвлөмж өгч, 1,2 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 3 албан шаардлага хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэлийн бүртгэл тайлагналтай холбоотой 15,4 төгрөгийн 39 алдаа илэрснээс аудитын явцад 15,4 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитор шалгасан нийцлийн асуудлаар нийт 188,8 тэрбум төгрөгийн 26 зөрчил илэрснээс 188,3 тэрбум төгрөгийн 14 албан шаардлага, 0,5 тэрбум төгрөгийн 12 зөвлөмж хүргүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 24 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11,9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл,

арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсөл, арга хэмжээний санхүүжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зам тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд харьяа 34 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 29 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай харьяа 23 байгууллагад өөрчлөлтгүй, 5 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт, 1 байгууллагад сөрөг дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 35,9 тэрбум төгрөгийн зөрчил ирснээс 0,4 тэрбум төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 30,9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 57 албан шаардлага хүргүүлж, 4,6 тэрбум төгрөгийн зөрчилд 106 зөвлөмж өгч хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 544,2 тэрбум төгрөгийн 52 алдаа илэрснээс 544,1 тэрбум төгрөгийн 47 алдааг аудитын явцад залруулж, 0,1 тэрбум төгрөгийн 5 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 260,4 тэрбум төгрөгийн 48 зөрчил илэрснээс 1 төлбөрийн акт тогтоож, 13,3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 11 албан шаардлага хүргүүлж, 209,1 тэрбум төгрөгийн зөрчилд 33 зөвлөмж өгч, 33 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 3 албан шаардлага хүргүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1 их наяд 577 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 408,8

тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 120 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсөл, арга хэмжээний санхүүжилт 92 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 64 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 53 байгууллагад дүгнэлт гаргаж, 11 байгууллагыг түүвэрт хамруулсан. Аудитаар төсвийн эрхлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай харьяа 39 байгууллагад өөрчлөлтгүй, 13 байгууллагад хязгаарлалттай, 1 байгууллагын санхүүгийн тайланд сөрөг дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 326,2 тэрбум төгрөгийн 157 зөрчил илэрснээс 0,2 тэрбум төгрөгийн зөрчилд 27 төлбөрийн акт тогтоож, 311,5 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 52 албан шаардлага хүргүүлж, 14,5 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 77 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 72,4 тэрбум төгрөгийн 86 алдаа илэрснээс аудитын явцад 51,5 тэрбум төгрөгийн 61 алдааг залруулж, 20,9 тэрбум төгрөгийн 5 алдааг дахин давтан гаргахгүй байх, арилгах зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 34,8 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 33,2 тэрбум төгрөгийн 28 албан шаардлага, 1,6 тэрбум төгрөгийн 42 зөвлөмж хүргүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 139 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 74,6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 47 төсөл,

арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсөл, арга хэмжээний санхүүжилт 91 хувийн гүйцэтгэлтэй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 24 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэсэнээс 17 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай харьяа 11 байгууллагад өөрчлөлтгүй, 6 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар 110,3 тэрбум төгрөгийн 145 зөрчил илэрснээс 1,6 тэрбум төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 65,7 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 63 албан шаардлага хүргүүлж, 28,6 тэрбум төгрөгийн 64 зөвлөмж өгч, 4,1 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 4 албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 10,1 тэрбум төгрөгийн 3 асуудлыг шилжүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1 их наяд 116,8 тэрбум төгрөгийн 85 алдаа илэрснээс аудитын явцад 1 их наяд 100,7 тэрбум төгрөгийн 69 алдааг залруулж, 16,5 тэрбум төгрөгийн 16 алдааг давтан гаргахгүй байх, түүнийг арилгах зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 303,5 тэрбум төгрөгийн 47 зөрчил илэрснээс 288,1 тэрбум төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага хүргүүлж, 15,4 тэрбум төгрөгийн зөрчилд 35 зөвлөмж өгсөн.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 онд санхүүгийн нэгтгэсэн тайланд

харьяа 33 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэсэнээс 30 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан хязгаарлалттай, харьяа 21 байгууллагад өөрчлөлтгүй, 8 байгууллагад хязгаарлалттай, 1 байгууллагад сөрөг дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар 105,8 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0,2 тэрбум төгрөгийн 53 төлбөрийн акт тогтоож, 89 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 85 албан шаардлага хүргүүлж, 15,2 тэрбум төгрөгийн зөрчилд 123 зөвлөмж өгч, хариуцлага тооцох 4 албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 0,5 тэрбум төгрөгийн 1 асуудлыг шилжүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 302,4 тэрбум төгрөгийн 81 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 47,6 тэрбум төгрөгийн 55 зөрчил илэрснээс 44,5 тэрбум төгрөгийн 29 албан шаардлага, 3,1 тэрбум төгрөгийн зөрчилд 26 зөвлөмж хүргүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 480,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 169 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 42 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 96 хувьтай хэрэгжсэн байна.

Аудитын дүн, дүгнэлтээс нэн тэргүүнд анхаарах асуудлыг тоймлон танилцуулъя.

Төсвийн эрхлэн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хэрэгжүүлэх дотоод хяналт шалгалт хангалтгүй. Төсвийн

төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх, төсөв хөрөнгийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн болон олон жилийн насжилттай эзэн холбогддоггүй болж, найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, ашиглах боломжгүй болсон автомашин, барилга, байгууламжийг холбогдох байгууллагуудад хандаж шийдвэрлүүлэх, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг сайжруулах, Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нийгмийн шинж чанартай төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь төсвийн нэгдсэн бодлогын зарчмыг алдагдуулж байгаа зөрчлийг арилгах, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны хараат бус ил тод байдлыг хангах талаар Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.

Танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Ганбаатар: Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотойгоор Сангийн сайд болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас аудитын дүгнэлтийн талаар Монгол Улсын Ерөнхий аудиторос асуулт асуух гишүүн байна уу?

Пунсалмаа гишүүнээр тасаллаа. Гишүүд асуулт асууна.

Энхтүвшин гишүүн асуултаа асууна уу.

Д.Энхтүвшин: 2 асуулт байна.

1 дүгээрт нь, хүү, торгуулийн орлого өнгөрсөн онд 77,1 тэрбум байж байгаад 166,3 болж нэмэгдсэн байна. Тэгээд энэ дээр энэ задаргаа байгаа юу? Жижиг, дунд аж ахуй эрхлэгчдийн, компаниудын ажил эрхлэгчид юу, ажилчдын тоогоор нь эрэмбэлсэн ямар хэмжээтэй аж ахуйн нэгжүүд энэ торгуульд илүү хамрагдсан бэ? Гол харах гээд байгаа санаа нь гэхээр жижиг, дунд аж ахуйн нэгжүүд дээр бас энэ яаж нөлөөлж байна вэ гэдгийг харах хүсэлтэй байна.

2 дугаарт нь, ашигт малтмалын нөөц ашигласны татвар бас нэмэгдсэн байгаа. Нэлээн бас том дүнгээр нэмэгдсэн байгаа. Мэдээж энд нөгөө жишиг биржийн үнээр борлуулсантай холбогдолтойгоор татварын орлого нэлээн нэмэгдсэн байх гэж харж байгаа. Тэгэхээр энэ дээр зарим нэг аж ахуйн нэгжүүдийн зүгээс бас байнга ярьдаг байсан энэ нөөц ашигласны татварыг жишиг үнээр тооцсоноос болоод зарим нь давхар татвар ноогдуулаа гэдэг асуудал ярьдаг.

Тэгээд үүнээс болоод жишигээр үйл ажиллагаа явуулах боломжгүй, хаалгаа барихад хүрч байна гэдэг асуудлууд яригдаж байсан.

Тэгэхээр энэ биржийн үнэ болон жишиг үнийн зөрөө яг бодит байдал дээр ямар байдалтай байгаа вэ? Тэгэхээр энэ дээр ийм 2 асуулт байна.

С.Ганбаатар: Сангийн сайдаас асуусан уу? Мөн ажлын хэсэгт байгаа нөхөд маань хариулахаар бол Жавхлан сайдын хажууд очоод 7, 6 дугаар ширээн дээр очиж суугаарай. Өөр асуултууд 2, 3 ч юм асуучихсан шүү дээ. Өөр асуултууддаа хариулж байх уу, тэгвэл.

Тэгвэл хуралдаан давхцаж байгаа, орж ирээд бас хариулах юм байна шүү, Энхтүвшин гишүүн ээ, болно тийм ээ.

Үүрийнтуяа гишүүн асуултаа асууж байна.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Надад 2 асуулт байна.

Эхний асуулт ХХААХҮЯ-наас асууя. Яамны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтын гүйцэтгэл гээд танилцуулагдсан байна. Яам болгоноор гарсан байна л даа. Би энэ харьяалах яамнаасаа асууя гэж бодож байгаа.

Гүйцэтгэл 98,3 хувьтай тухайн оных гэсэн үг. 2023 оны төсөв гүйцэтгэлийн харьцаагаар бол 98,3 хувьтай. Төсөвт өртөгтэй харьцуулахаар энэ бол өөр дүн харагдахаар. Гэхдээ энд мэдээлж байгаа бид нарыг мэдээллээр хангаж байгаа, гишүүдэд өгч байгаа мэдээлэл дээр бол төсөвт өртгөөсөө тооцохоор өнөөдөр ямар, хэдэн хувийн гүйцэтгэлтэй яваад байгаа юм. Энэ төслүүд нийтдээ. Гүйцэтгэл нь хэдэн хувьтай, санхүүжилт нь хэдэн хувьтай яваад байгаа юм. Эхэлсэн хугацаа харилцан адилгүй төслүүд байгаад байна. Өөрөөр хэлбэл хамгийн дээд тал нь хэдэн жилийн насжилттай хөрөнгө оруулалт энд яваад байгаа юм бэ. Гүйцэтгэл ямар байгаа юм бэ гэдэг үзүүлэлтүүд бол эндээс харагдахгүй байгаад байна л даа.

Тийм учраас нийт төсөвт өртөгтэй харьцуулахад 23 оны байдлаар нийт төслүүдийн гүйцэтгэл санхүүжилтээрээ хэдэн хувьтай байгаа юм, ажлаараа хэдэн хувьтай байгаа юм. 1 дүгээрт.

2 дахь асуудлыг би Үндэсний Аудитын газраас тодруулах гэсэн юм. Үндэсний аудитын газрын дүгнэлт дээр төсвийн ерөнхийлөн захирагчдын зарим ерөнхийлөн захирагчдыг жишээ болгож аваад нийтлэг нэг ийм дүгнэлт хийсэн байна. Тэр болохоороо гүйцэтгэлээс давсан санхүүжилт олгож байна гэж.

Тэгэхээр яг манай харьяалж байгаа энэ 2 яамны хувьд гүйцэтгэлээс давсан хөрөнгө оруулалтын санхүүжилт илүү олгогдсон тийм зөрчил дутагдлууд байна уу? Ийм 2 асуулт байна.

С.Ганбаатар: Хөдөө аж ахуйн яамнаас эхлээд хариулах уу? Нэр усаа хэлээд танилцуулаад. 7 дугаар микрофон, 7 дугаар ширээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн гишүүний асуултад хариулъя.

2023 оны төсвийн гүйцэтгэлээр, үндсэндээ төсөвт өртөг нь 138,9 тэрбум төгрөг 23 онд санхүүжих дүн нь 74,6 сая төгрөг. Гүйцэтгэл бол 73,4 сая төгрөгтэй, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 98,4 хувьтай. Энэ дотроо барилга, байгууламж 44,9 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж 28,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй.

Ялангуяа Улсын Их Хурлын гишүүд салбарын бодлого үйл ажиллагаатай холбоотой шинэ хөдөө хөгжүүлэх гэдэг юм уу, энэ богино хугацааны нэг удаагийн шинжтэй төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдийн санхүүжилт, гүйцэтгэл бол өндөр хувьтай.

Үйлдвэр технологийн парктай холбоотой Ховд үйлдвэр технологийн парк гэдэг юм уу, томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн ажилтай холбоотой үйл ажиллагаанууд бол он дамжсан нэлээн тийм сунжирсан үзүүлэлтүүд байгаа. Гэхдээ манай дээр хамгийн том дүнтэй гэдэг юм уу, явж байгаа төсөл, арга хэмжээ нь Ховд үйлдвэр технологийн парк байгаа. Нийтдээ 35,9 тэрбум төгрөгийн санхүүжилттэй. Өнөөдрийн байдлаар санхүүжилт бол нэг 21,6 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан. Төслийн гүйцэтгэл нэг 80 хувьтай энэ ондоо багтаад бид нар 100 хувьд хүргэчих ийм

төлөвлөгөөтэй. Үлдэж байгаа 14 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 25 ондоо дамжуулаад өгөх ийм л дүнтэй байж байна.

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Би тодорхой л тоо асуугаад байгаа юм л даа. 138,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй энэ ажлын гүйцэтгэл нь 23 оны жилийн эцсээр хэд байгаа юм бэ? Төсөвт өртөгтэйгөө харьцуулаад аваад үзэхээр гүйцэтгэл нь санхүүжилт нь хэдэн хувь нь олгогдчихоод байгаа юм бэ? Ажлаар нь 138 тэрбум төгрөгийн ажлыг ажлаар нь аваад үзэх юм бол ажлынх нь хэдэн хувь нь гүйцэтгэгдчихээд байгаа юм бэ гэдэг юмыг л би асуугаад байгаа юм.

С.Ганбаатар: Тодорхой тоо, хувь асууж байна.

Т.Жамбалцэрэн: Нийт дүнгээрээ аваад үзэхээр 73,4 хувийн гүйцэтгэлтэй байна.

С.Ганбаатар: Ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

Үүрийнтуяа гишүүн тодруулах зүйл байна уу. Болсон уу. Санал дээр хэлэх үү.

Гишүүдийн асуултад бас их тодорхой хариулах ёстой шүү. 4 дүгээр микрофон, Загджав дарга, Ерөнхий аудитор.

Д.Загджав: Баярлалаа. Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Тийм илүү, дутуу санхүүжилт олгосон зүйл бол ер нь бол Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 3,6 км зам дээр байгаа. Түүнийг ажлын гүйцэтгэлийг дуусгаагүй баталгаажуулж санхүүжилт олгосон байгаа. Энэ алдаа дутагдлыг залруулахад албан шаардлага бид хүргүүлээд ажиллаж байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний асуулт нь давхацчихлаа. Ерөнхийдөө Жавхлан сайд бас манай Үндэсний аудитын газрынхан байгаа юм чинь нэг 2 асуулт асуучихъя гэж бодлоо.

Өмнөх оны аудиторын өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 72,2 хувьтай байна. Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 зөвлөмж хэрэгжих шатдаа, Монгол Улсын Шадар сайд 1 зөвлөмж хэрэгжих шатдаа гээд ингээд яваад байдаг. Өмнөх онуудынх нь харахаар ингээд байдаг.

Ингээд ер нь жил болгон энэ манай энэ Үндэсний аудитын газар чинь яг энэ Монгол Улсын болж байгаа, болохгүй асуудлуудыг гаргаж ирж тавьдаг. Үүний яг, үүнийг биелүүлэхгүй байх шалтгаан нь юу бол байгаад байгаа юм бэ гэж асууя, 1 дүгээрт нь.

2 дугаарт нь гэх юм бол Сангийн сайд байна. Бид бас энд Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, аудитыг нэлээн харлаа.

Тэгээд ААН байгууллагын энэ орлого төвлөрүүлэлт бол үнэхээр сайн хийгдсэн юм байна. Сүүлийн 2, 3 жил бол энэ аж ахуйн нэгжүүд бүсээ чангалж байгаад бид нар бол ерөөсөө дансаа хаалгаж байгаад татвараа төлөөд байна гэсэн. Энэ бол энэ цаасан дээрх тоогоор бол үнэн юм байна. Нэг талдаа.

Нөгөө талдаа болохоор яг энэ ТӨК-ууд чинь асар их алдагдалтай ажиллаж байна гээд. Энэ аудитын дүгнэлт дээр, дүгнэлтийн 5 дээр ингээд байгаад байдаг тийм ээ. Эрдэнэс тавантолгойгоос бусад ТӨК-ууд этгээдүүдийн өмнөх оноос 9 хувь, өр төлбөр 9,6 хувь, ашиг 5,4 хувиар буурсан. 26,2 хувиар буурсан гээд ингээд байгаад байдаг.

Тэгэхээр энэ ТӨК-ууд чинь яг бодитойгоор ер нь цаашидаа яах юм бэ, сангийн сайд аа гэдгийг Сангийн сайдаас асуух гэсэн юм.

3 дахь асуулт нь болохоор Монгол Улсын нийт өрийг 2, 3 янзаар тайлбарлаад, үгүй ээ, нийт өрийг 2, 3 янзаар ингээд тайлбарлаад байдаг. Энэ дээр нэг та нэг бас яг гадаад өр яг хэдтэй байгаа юм бэ? Аудитын дүгнэлт дээр бол тайлант онд Сенчиригаас 2, сенчири 3 үнэт цаасны олон улсын зах зээл дээр арилжаалсан эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасгасан гээд Гэрээг болон энэ Хуралдай үнэт цаасны төлбөрийг төлчихсөн гэж харагдаад байдаг.

Тэгээд өрнөөс өрний хооронд яваад байгаа юм уу. Нэг болохоор ингээд ашигтай байгаад байна, 700 хэдэн тэрбум гээд байдаг. Тэгээд энэ дээр та 1 нэгдсэн ойлголт өгөөч ээ гэж Жавхлан сайдаас бас асуух гэсэн юм.

С.Ганбаатар: Эхлээд Аудитын ерөнхий газраас хариулчихъя. Дараа нь 5 дугаар ширээ Жавхлан сайд хариулах байх. 4 дүгээр ширээн дээр.

Д.Загджав: Баярлалаа. Очирбат гишүүний асуултад хариулъя. Та их зөв зүйтэй зүйлийг хөндөж асуулаа. Бид бүхэн бас ер нь төрийн төсөв санхүүг байнга хянаж, холбогдох арга хэмжээ авч, хууль, эрх зүйн хүрээнд ажиллаж байгаа. Ер нь өмнөх жилүүдэд ийм асуудлууд бас яах вэ, хэрэгжилт нь удааширах ийм зүйлүүд байгаад байсан. 2023 онд батлагдсан Төрийн аудитын байгууллагын тухай хуульд орсон өөрчлөлтөөр бид нар бас энэ яг манай мөрөөр авах арга хэмжээ, төлөвлөгөө гаргаад, тэгээд тэр төлөвлөгөөний дагуу 30 хоногийн дотор арга хэмжээ аваад, манайд хариу ирүүлдэг ийм эрх зүйн зохицуулалт 24 оноос бас хэрэгжиж эхэлж байгаа.

Тийм болохоор энэ ажил нэлээн сайжрах болов уу гэж ойлгож байна. Ер нь бол энэ төрийн хяналт шалгалтыг, Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийг бид бүхэн хэрэгжүүлж ажилладаг. Энэ дээр бас эрх зүйн зохицуулалт, дэмжлэг хэрэгтэй байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Сангийн сайд Жавхлан 5 дугаар ширээн дээр.

Б.Жавхлан: Сүүлийн жилүүдэд ялангуяа ковидын эхний 2 жил нэлээдгүй хүнд ийм төсвийн нөхцөл байдалтай байсан. Уучлаарай Очирбат гишүүний асуултад хариулж байгаа шүү, уучлаарай.

Тэгээд сүүлийн 2 жилийн хугацаанд эдийн засаг бас харьцангуй тогтворжиж ирсэн. Ингээд хэдийгээр улсын төсөв алдагдалтай гэж хууль батлагдаж байсан боловч гүйцэтгэл ингээд та бүхэнд танилцуулж байгаагаар бол эерэг гараад явж байгаа. Ямар ч байсан төсвийн орлогоо дутуу төлөвлөөгүй гэсэн үг. Зардлын хувьд аль болох хэмнэлттэй ингээд явсны үр дүн ийм байгаа юм.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар төрийн өмчийн бүх аж ахуйн нэгжүүдийгээ хариуцаж бодлогоо хэрэгжүүлж явдаг. Танд би өөрөө мэдэж байгаа мэдээллээрээ мэдээллүүдээ тайлагнаж.

2 жилийн өмнө 2023 онд, 2022 онд Засгийн газрын тогтоол гаргаад төрийн өмчийн 108 компани дээр иж бүрэн аудит хийгээд, түүнийг нь ер нь 3 ангилсан юм. Стратегийн хувьд ер нь ингээд төрдөө байх хэрэгтэй. Энд цахилгаан станцууд, Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс тавантолгой гээд гэх мэтчилэн 10 гаруй компани. Мөн дундын одоогоор бол эдийн засгийн ашигтай. Гэхдээ цаашидаа үйл ажиллагааг нь сайжруулах, менежментийг нь сайжруулж эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нь

нэмэгдүүлэх боломжтой гэсэн ийм компаниуд. Мөн шууд татан буулгах ийм 3 янзаар ангилаад ингээд бүтцийн өөрчлөлт бол 2 жилийн хугацаанд хийгдэж байгаа. Энэ хүрээнд яг би хариуцаж байгаагаа танд хэлье.

Манай Сангийн яамны харьяанд бол Хөрөнгийн бирж байсан, байдаг. Хөрөнгийн биржийг 34 хувийг нь ХК болгож, нээлттэй компани болгосон. Энэ бол маш амжилттай явсан. Мөн Төрийн банк байна. Төрийн банкны 5 хувь одоогоор биржтэй ... /минут дуусав/

С.Ганбаатар: 5 дугаар ширээн дээр Жавхлан сайд тодруулъя. Нэмэлт 1 минут.

Б.Жавхлан: Тэгээд өрийн талаар ийм байгаа шүү. Монгол Улсын өр гэдэг ойлголт байна. Засгийн газрын өр гэдэг ийм ойлголт байгаа. Мөн улсын секторын өр гэсэн ийм 3 янзын ийм өрийн ийм тодорхойлолт ойлголт байдаг.

Улсын өр гэхээр энд Засгийн газрын өр, Хөгжлийн банкны өр, улсын төрийн өмчийн үйлдвэрийн газрууд, мөн Засгийн газрын төрийн оролцоотой Оюутолгой гэх мэт ийм компаниудын өр. Тэгээд хувийн секторын өрүүд бүгд нийлээд хувийн секторын гэхээр банкнуудын гадаад данс, гадаад өрүүд бүгд ороод гэсэн үг. Ингээд одоогоор 30, өөрөөр хэлбэл улсын өр гэсэн үг шүү. Улсын өр одоогоор 34,6 тэрбум доллар байна. Үүнээс 7,9 тэрбум доллар нь Засгийн газрын гадаад өр байна. Ийм байдалтай байна.

Яг Засгийн газрын өр бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар ДНБ-ий 60 хувиас хэтэрч болохгүй ээ гэсэн хязгаартай байгаа. Одоогоор 23 оны та бүхний өмнө байгаа гүйцэтгэлээрээ 39 хувьтай байгаа гэсэн үг.

С.Ганбаатар: Асуултад.

Б.Жавхлан: Манай Цогбадрах дарга нэмж хариулъя гэж байна.

С.Ганбаатар: Цогбадрах дарга 8 дугаар микрофоныг өгье.

Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах Очирбат гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Өмнөх Сангийн сайдын төлөвлөгөө батлах тухай 2023 оны 163 дугаар тушаалыг гарган бид нар Үндэсний Аудитын газраас өмнөх оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 22 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нь Аудитын үндэсний газраас бид нарт нийт 15 зөвлөмж, 3 шаардлага өгөгдсөн байдаг.

Үүний зөвлөмжийн биелэлт бол 89,1 хувьтай, албан шаардлагын биелэлт 85 хувьтай гарсан байна. Үүнээс Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд 11 албан шаардлага өгснөөс 10 нь 100 хувийн биелэлттэй, 1 нь 70 хувийн биелэлттэй. Нийт биелэлтийн хувь нь 97,2 хувь.

2022 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд өгсөн 3 албан шаардлага бол гурвуулаа 100 хувь биелсэн, зөвлөмж. Албан шаардлагын хувьд бол өгөгдсөн нийт 3 албан шаардлагын 2 нь 100 хувь, 1 нь 70 хувийн биелэлттэй гарсан байна.

С.Ганбаатар: Сангийн яамны орлогын газрын дарга Тэлмүүн орж ирсэн. Бусад хурлуудтай бас давхцаж байсан учраас Энхтүвшин гишүүн маш чухал асуулт асуусан. 6 дугаар микрофон дээр хариултаа өгнө үү. Тодруулж байгаа юм байна.

Тэгвэл Лувсанжамц гишүүн асуултаа асууна уу.

Г.Лувсанжамц: Сайн байцаана уу. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас асуух 2, 3 асуулт байна. Нийт төсвийн зарлагын гүйцэтгэлийг харахаар нийт хөрөнгө дотроос нийт төсвийн бараг талаас илүү нь татаасаар явж байна. Тэгээд хувийн хэвилийн байгууллагад олгох татаас нийтдээ 256 тэрбум төгрөгөөр байна. Тэгээд үүний гүйцэтгэл нь 45,6 хувиар гэж байна. Энэ яагаад 45,6 юм бол гээд эхний асуулт байна.

2 дахь асуулт нь болохоор ийм их татаасыг олгож, ямар байгууллагад ямар шугамаар яаж олгож байгаа юм бэ. Жижиг, дунд үйлдвэрлэгчдэд хэр хүртээмжтэй байгаа юм бэ гэдэг нь 2 дахь асуулт байна.

3 дугаар асуулт болохоор Аудитын газраас ХХААХҮ-ийн сайдад зөвлөмж өгсөн байна л даа. Нийтдээ 139 тэрбум төгрөгийн барилга, байгууламж болон тоног, төхөөрөмж зэрэгт зарцуулсан байна.

Тэгээд эдгээр барилга, байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үржлийн мал зэрэг ашиглагчийг нээлттэй ил тод, өрсөлдөөнт зарчмаар сонгон шалгаруулаад, үйлдвэрлэлдээ дотоодын үйлдвэрлэлийг оновчтой үр ашигтайгаар дээшлүүлэх тийм чиглэсэн журам боловсруулах ёстой гэж байна. Үүнийг боловсруулж байгаа болов уу? Ямар шатдаа явж байгаа вэ гэсэн 3 асуулт байна.

С.Ганбаатар: Эхлээд Хөдөө аж ахуйн яамнаас хариулт өгье. 7 дугаар ширээн дээр.

Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. Төсвийн зарлагын гүйцэтгэлтэй холбоотой асуулт асууж байна. Үндсэндээ ХХААХҮ-ийн сайдын төсвийн багц улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь хэмжээ бол 2023 оны байдлаар нэг 2,9 хувьтай ийм байсан.

Нийтдээ нэг 490,9 тэрбум төгрөгийн төсөвтэй. Эндээс татаас, урамшуулалтай холбоотой зардал нь нэг 200 гаруй тэрбум төгрөг байгаа. Энэ дотроо ХАА, хөдөөг дэмжих зээлийн хүүгийн хөнгөлөлт, ноолуурын зээлийн хүүгийн хөнгөлөлт, Зээлийн батлан даалтын сангийн төлбөр, зээлийн хүүгийн хугацаа сунгахтай холбоотой энэ 2023 оны 11 сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэгтэй, Засгийн газрын шийдвэртэй.

Нөөцийн мах бүрдүүлэхэд олгодог зээлийн урамшуулал, гурилын нөөц бүрдүүлэхтэй холбоотой, ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих зээлтэй холбоотой, хүнсний хөтөлбөртэй холбоотой дандаа татаас урамшууллауд байгаад байгаа юм. Эд нар нь өөрсдөө Улсын Их Хурлын тогтоол шийдвэрүүдтэй.

Хүнсний хөтөлбөр гээд тэгэхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамж аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн гээд Их Хурлын 36 дугаар тогтоолтой байж байна.

Ноос, ноолуур, арьс ширний урамшууллауд гээд эргээд эдгээр урамшууллауд маань иргэн, аж ахуйн нэгжүүдээрээ баталгаажгаад татварын и-баримтын системээр баталгаажгаад иргэн, аж ахуйн нэгж дээр шууд очиж байгаа урамшууллауд байгаад байгаа.

Нөгөө талаараа арилжааны банкны эх үүсвэрээр гарч байгаа зээлийн хүүгийн хөнгөлөлтүүд байгаа.

Тэгээд энэ дүнгээрээ аваад үзэхээр ийм өндөр дүнтэй бараг төсвийнхөө 50 хувийн татаас урамшуулалтай ингээд ороод явчхаж байгаа юм.

Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой зардлууд нь гээд тэгэхээр он дамжаад санхүүждэг ийм арга хэмжээнүүд байгаа. Ялангуяа арьс ширний

урамишуулал, ноосны урамишуулал гэдэг юм уу, тухайн жилийн авч байгаа урамишууллууд нь дараа жилдээ он дамжаад олгогдохдог учраас гүйцэтгэл нь ийм 45,6 хувийн ийм хэмжээтэй байгаа.

Хөрөнгө оруулалт, барилга, байгууламжтай холбоотой тэр 38,9 тэрбум төгрөгийн арга хэмжээ гээд энэ Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу ХХААХҮ-ийн сайд төсвийн Ерөнхийлөгчийн захирагчийн тушаал гараад өгсөн зөвлөмжийн дагуу биелэлтүүдийг хангаад ажиллаж байгаа. Энэ хүрээндээ холбогдох энэ барилга, байгууламж, бараа материал, тоног төхөөрөмж, шинэ хөдөө төслүүд дээр нийлүүлээд явж байгаа тоног төхөөрөмжүүдийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас гаргасан хууль дүрэм, журмын хүрээнд нь төрийн өмчийг ашиглах, эзэмшүүлэх, журмын дагуу ашиглуулах ажлыг зохион байгуулж байна.

Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар дамжуулаад орон нутгийн өмчид бүртгүүлэх ажлуудыг зохион байгуулж байгаа.

Дээр нь төсвийн сахилга батыг сайжруулах чиглэлээр аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу эргээд сөрөг үнэлгээтэй, сөрөг дүгнэлттэй байгаа ажлууд дээр бол холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг аваад, дараа дараагийн жилийн төсвүүд дээр эдгээр ... /минут дуусав/

С.Ганбаатар: Ажлын хэсгийн 7 дугаар микрофонд нэмж минут өгье.

Т.Жамбалцэрэн: Ялангуяа нийтлэг гардаг зөрчил дутагдал гээд тэгэхээр энэ шинэ хөдөө төслүүд өнгөрсөн 2023 оны төсөв дээр 11 ажил, арга хэмжээ 22,1 тэрбум төгрөгийн төсөвт ажлууд хийгдсэн. Үүнд Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан бодлого

шийдвэртэй уялдаж хийгдэж байгаа. Сайн үр дүнд хүрч байгаа шинэ хөдөө төслүүд байгаа. Үр дүнд хүрэхгүй бараа материалууд авдаг, тоног төхөөрөмжүүд авдаг, эргээд эзэн холбогдохчид нь тодорхойгүй, эргээд нөгөөдөх нь хөрөнгө нь шамшигддаг ийм зөрчилтэй асуудлууд бас байгаа.

Тэгээд эдгээр асуудлуудыг аль болох дараа дараагийн жилийн төсвүүдэд тавихгүй байх, энэ саналыг Улсын Их Хурал, Засгийн газарт хэлэлцүүлэхэд нь аль болох тусгахгүй байх чиглэлийн ажлуудыг сайдын эрхлэх асуудлын төсвийн хүрээний байгууллагууд дээрээ төсвийн сахилга батыг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа.

С.Ганбаатар: Аудитын газраас бас асуулт асуусан шүү. 3 дугаар, ажлын хэсгийн 3 уу, 4 үү? Ажлын хэсгийн 1 дүгээр микрофонд.

Д.Энхболд: Лувсанжамц гишүүн Үндэсний Аудитын газраас ХАА-н хөнгөн үйлдвэрийн сайдад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хэрхэн биелүүлж ажиллаж байна вэ гэдэг чиглэлээр, үүгээр ямар арга хэмжээ авч байгаа гэж асуусан байх. Манайхаас бол хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон үйлдвэр, агуулах, зорь, хүлэмж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үржлийн малаа зэргийн ашиглагчийг нээлттэй, ил тод, өрсөлдөөнт зарчмаар сэргээх, сонгон шалгаруулах оновчтой, үр ашигтай ашиглахад чиглэсэн журам, заавар боловсруулан баталж, нэгдсэн арга зүйгээр хангах, хэрэгжилт, үр дүнг бүртгэх, тайлагнах тогтолцоог бүрдүүлэх гэдэг ийм зөвлөмж өгсөн.

Хуулийн дагуу 30 хоногийн дотор зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө Хөдөө аж ахуйн яамнаас бол ирүүлсэн байгаа. Хэрэгжилт хангагдах хугацаа бол 12 сарын 01-ний дотор. Хугацаа арай болоогүй байгаа.

С.Ганбаатар: Ажлын хэсгийн 7 дугаар микрофон дээр ХААЯ яг энэ асуудал дээр явц ямар байгаа вэ? Гишүүнд тодорхой хариулт өгнө үү?

Т.Жамбалцэрэн: Энэ чиглэлээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас төрийн өмчийг ашиглах, эзэмшүүлэх журамтай холбоотой хэрэгжилтийг хангаад ажиллаж байгаа. Яг юу гэдэг юм, салбар дээр тэр нээлттэй, ил тод сонгон шалгаруулах асуултыг бид нар холбогдох зар мэдээллийг нээлттэй Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээндээ холбогдох ажлыг зохион байгуулаад явж байгаа.

Энэ өөрөө барилга, байгууламжтай холбоотой, бараа материалтай холбоотой, тэр удмын сангийн цөм сүргийн ашиглалттай холбоотой асуудлууд тусгагдсан. Эдгээр асуудлуудыг бид нар Төрийн өмчийн бодлого зохицуулалтаас газраас гаргасан тэр зөвлөмж журмын дагуу хэрэгжилтийг хангаад ажиллаж байгаа.

Зөрчил дутагдлыг бол арилгах чиглэлээрээ холбогдох төлөвлөгөөгөө гаргаад, батлуулаад хэрэгжилтийг хангаад ажиллаж байгаа. Тэгээд тайлан тооцоо, биелэлтийг гаргана.

С.Ганбаатар: Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа асуулт асууна.

Б.Пунсалмаа: 2023 оны төсвийн гүйцэтгэл хэлэлцэж байгаа энэ үед 1 асуулт байна. 2023 оны төсвийн тайлан үзэж байхад Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайд бүхий хороо байгуулагдсан. Энэ хорооны төсөвт зардал нь 108 тэрбум төгрөг 2023 онд энэ яам зарцуулсан байна. Үр дүнг нь бид нар бүгдээрээ харж байгаа. 2024 оны зуны олимпод Монгол Улсаас 1 тамирчин мөнгөн медаль хүртсэн. Гэтэл бид нар энэ өмнө нь яг ийм олимпын яамгүй байхдаа бид нар бас дэлхийн аварга, алтан, мөнгөн медалиуд авч байсан.

Тэгээд яагаад ийм богино хугацаатай, 1 жилийн ийм эдийн засгийн ийм томоохон төсөв зардал бүхий ийм яам байгуулчхаад, ийм богино хугацаанд энэ яамыг шилжүүлээд өөр тийш нь оруулчхав уу гэдэг нь асуулт өгч байна.

Тэгэхээр цаашидаа бид нар ингэж ийм үрэлгэн зардал гаргахгүй байхын тулд энэ төсөвт зарцуулалтаа бид нар яаж хянах вэ гэдэг дээр анхаарах хэрэгтэй. Монгол Улсад өнөөдөр энэ 108 тэрбум төгрөгийн зарцуулалтыг бий болгохын тулд хэчнээн аж ахуйн нэгжүүд хэдий хэмжээний татвар төлж, яаж энэ дансаа хаалган барин байж, энэ татварыг төлдөг билээ. Тийм ээ, үүнийг бодолцож бид нар цаашидаа бас ийм үрэлгэн нэг жилийн ийм богино мөчлөгтэй ийм шийдвэрүүд гаргахгүй байх дээр анхаарах хэрэгтэй байна.

2024 оны энэ төсвийн юун дээр ч гэсэндээ бид нар арьс шир боловсруулах үйлдвэрийг бас энэ төсвийг хойшлуулсан байгаа, 11 тэрбум төгрөг. Гэхдээ зэрэг энэ яг үйлдвэрлэл, төсвийн орлогыг нэмэгдүүлэх энэ төсөв зарцуулалт дээрээ анхаараад, иймэрхүү зардлуудыг багасгах тал дээр анхаарах хэрэгтэй гэж хэлье.

С.Ганбаатар: Тэр Арьс ширний үйлдвэртэй холбоотой асуудал дээр Хүнс, хөдөө аж ахуйн яам ажлын хэсгийн 7 дугаар микрофон байгаа. Ер нь бол аж үйлдвэрлэгчид энэ татварыг нь бүрдүүлж мөнгө гаргаж, ингээд явуулж байгаа зүйл дээр үр дүн ер нь хэр байна вэ гэдэг асуултыг бас Жавхлан сайд хариулна биз дээ.

Ер нь яг нарийн яривал бүх л аж үйлдвэрлэгчдийн мөнгийг араас нь хянаж байгаа, араас нь үр дүнг нь хянаж байгаа зүйл байна уу гэсэн ийм 2 асуулт асуулаа. Ингээд ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

Т.Жамбалцэрэн: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Арьс ширний үйлдвэртэй холбоотой асуудал,

хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай, орон нутагтай хамтраад орон нутгийн өмчит компани байгуулаад ажилласан. Эргээд энэ байгууллагын үйл ажиллагаа маань өөрөө хууль, шүүхийн байгууллага дээр маргаан үүссэн.

Энэ хувийн хэвшлийн эхлүүлсэн бүтээн байгуулалтын ажил дээр төр оролцоод хамтраад энэ ажлыг эхлүүлээд явъя гэдэг санаачилга гаргаад явсан боловч эргээд нөгөө хууль, шүүхийн маргаан нь эцэслэн шийдвэрлэгдээгүй учраас хамтраад ажиллах бололцоо бүрдээгүй. Энэ хүрээндээ Дарханы арьс ширний цогцолбор ТӨК-ийг байгуулаад, орон нутгаас тодорхой 25 га газрыг гаргуулаад, суурь дэд бүтцийн ажил, ТЭЗҮ-ийн зураг, төсвийн ажлыг нь бол гаргачихсан явж байгаа.

Шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Дархан үйлдвэр технологийн парк байгуулах агуулгад тусгагдсан энэ Дарханы үйлдвэр технологийн парктэй энэ арьс ширний үйлдвэрийг нь нэгтгэн зохион байгуулаад энэ ажил хэвээр үргэлжлээд явна. Зөвхөн юу гэдэг юм, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ цэнийг өсөн нэмэгдүүлэхтэй холбоотой агуулгаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Цагаан алт хөтөлбөрт энэ агуулга бүрэн бүрэлдэхүүнээрээ бас туссан учраас хэрэгжилт нь бол сайн гарах болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Дээр нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай хөнгөн үйлдвэрлэлийн парк Говьсүмбэр аймагт байгуулахаар холбогдох зөвшөөрлөө аваад ингээд ажиллаж байна.

Дээр нь Өвөрхангай аймагт ноос, арьс ширний үйлдвэрүүд бас Монгол Улсын Засгийн газартай хэрэгжүүлж байгаа ОУБ төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр ингээд үйлдвэр аж ахуйн газрууд байгуулагдаад ажиллаж байгаа. Түрүүн хэлсэн Дарханы арьс ширний

парк, Дарханы хөнгөн үйлдвэрлэлийн паркийн үйл ажиллагааны суурь дэд бүтцийн ажил өнөөдрийн байдлаар нэг 80 хувьтай. Энэ ондоо багтаад бид нар 100 хувь дэд бүтцийн ажлыг нь хүлээгээд авчихна.

Тэгээд ирэх жилүүдэд хувийн хэвشلүүд өөрсдөө боловсруулах үйлдвэрүүдийн хөрөнгө оруулаад энэ баруун бүсэд байгуулах юм.

С.Ганбаатар: Жавхлан сайд хариулах уу? Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Дээр нь нэмээд нэг хэлэхэд Энхтуяа гишүүний микрофоныг бас хэлэх үгийг бичээрэй. Энэ дээр тэмдэглэж амжсангүй шүү. Энхтуяа гишүүн дараа нь үг хэлнэ. Дараа нь Тэлмүүн бас Энхтүвшин гишүүний асуултад хариулна шүү.

Жавхлан сайд 5 дугаар микрофон.

Б.Жавхлан: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Ер нь Монгол түмэн маань бүх нийтээрээ л бид олимпоос амжилт хүлээж байлаа. Харамсалтай нь бас санаанд хүрсэн тийм амжилт гараагүй гэж олон нийт үзэж байх шиг байна. Тэгэхдээ энд нэг ийм ойлголт байгаа шүү, Пунсалмаа гишүүн ээ.

Төсөв бол төрийн үйл ажиллагааг төрийн үйлчилгээг бүрэн санхүүжүүлэх, төрийн үйл ажиллагааг тасалдуулахгүй байх ийм үндсэн үүрэгтэй. Эрүүл мэнд, спорт, боловсрол, эрүүл одоо нийгмийн халамжийн бүхий л төрлийн үйлчилгээнүүдийг бид бүрэн санхүүжүүлэх төсөвт тусгагдсан байдлаар ийм үүрэг хүлээдэг, төсөв, Сангийн яам.

Нарийн яг мэргэжлийн чиг үүргээ хариуцаж байгаа энэ төсвийн ерөнхийлөн захирагч нар маань тэр төрийн үйлчилгээг аваад үзүүлээд, хэрхэн ямар үр дүн гаргав. Хэрэв үр дүн

гараагүй бол яаман дээрээ алдав гээд яг бүхий л энэ салбарууд дээрээ үнэлэлт дүгнэлт өгч олон улсын стандарт үнэлгээгээр энэ дээрээ үр дүнгээ гаргаж тайлагнаж байх ёстой юм.

Тэгэхээр тэр жишээ нь спорт олимптой холбоотой энэ ямар, яагаад илүү үр дүн гаргасангүй вэ гэдэг ийм асуудлууд дээр яг мэргэжлийн яам нь өөрсдөө их сайн хариулах хэрэгтэй. Харин бид талаас 1 төгрөг болгон яг хуулийн дагуу зохих зүйлдээ зарцуулагдсан байна уу, үгүй юү гэдгийг л бид хянаж, мөн аудитын байгууллагынхан давхар хянадаг ийм үүрэгтэй байгаа. Тийм.

С.Ганбаатар: Энхтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Энхтуяа: Өдрийн мэнд хүргэе. Бид нарт энэ материал маш богино хугацаанд тараагдсан учраас бүгдтэй нь танилцаж амжсангүй. Гэхдээ бас надад асуулт байна.

Мэдээжийн хэрэг бид нар өнгөрсөн 2023 оны энэ төсвийн гүйцэтгэлийн асуудлыг ярилцаж байгаа учраас энэ Улаанбаатар хотыг тойрсон маш томоохон асуудлууд байдаг.

Тэгээд сая бас нэг зүгээр хэвлэлээр харж байгаа, явахад та бүхэн бас бусад Байнгын хороод дээр ярилцсан юм шиг байна. Зүгээр, би бас нийслэлийн төлөөлөгчөөр ажиллаж байсан хүний хувьд нийслэл дээр маш олон төсөл, хөтөлбөрүүд хэрэгждэггүй. Ганцхан жишээ хэлье. 2022, 2023 онд эл ар ти, би ар ти гээд том төслүүд хэрэгжүүлнэ ээ гээд. Энэ төслүүдийн зарцуулах хэмжээ нь 2,8 тэрбум долларын асуудалтай, төсөвтэй.

Дээрээс нь Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт гэдэг компани байгуулаад тэгээд энэ компанийн үйл ажиллагаа бол нэлээд урт хугацаанд явагдаж байсан хамт олон, мөн ТУЗ гээд

ингээд төсөв хэрэглээд явж байсан. Харамсалтай нь 2023 оны сүүлээр энэ нь хэрэгжих боломжгүй ээ гээд энэ компанийг бол татан буулгасан.

Бас нэг жишээ дурдахад 2021 онд дүүжин тээвэр ашиглалтад оруулна. Дүүжин тээвэр бол Улаанбаатар хотын түгжрэлийг 25 хувиар бууруулна гэсэн ийм төсөл оруулж ирсэн. Мэдээжийн хэрэг Монгол Улсын хүн амын тал нь амьдарч байгаа Улаанбаатар хотод орж ирж байгаа энэ томоохон төслүүдийг Их Хурал дээрээ ч тэр, мөн Сангийн яаман дээр ч тэр, Нийслэлийн Иргэдийн Хурал дээр ч тэр дэмжээд л явуулдаг. 60 сая еврогийн Францын Засгийн газрын зээлийн энэ хүүд жил болгон хүүгийн төлбөр төлөгдөөд л явсан байх, тийм ээ. Ингээд энэ дүүжин тээврийн асуудал бас дампуурсан. Энэ компанийг бас татан буулгасан.

Хамгийн ноцтой юм бол энэ Тавантолгой түли гэдэг энэ компани байгаа. Тэгээд энэ компани дээр бас нэлээн олон удаа очиж байсан. Нөхцөл байдал бол маш хүнд. Үүнийг байнга ярьж хэлдэг. Үүний хамгийн төсөвт зарцуулсан юм нь 44,6 тэрбум төгрөг зарцуулчихсан. Өнөөдөр бол та бүхэн бол энэ компанийн асуудал бол маш хүндрэлтэй байгаа юм байна гэсэн ийм дүгнэлтийг гаргасан юм шиг байна тийм ээ. Үүнийг бас яг ямар дүгнэлт гаргасан юм бэ? Үүнийг бас асууж байна.

Хамгийн аймшигтай хохиролтой зүйл бол 2018 оноос энэ Тавантолгой түли гэдэг компани үйл ажиллагаа эхэлснээс хойш манай ХСҮТ-ийн эмч нар бүрэн энэ асуудалд бол хариулт өгсөн байгаа. Юу гэхээр элэгний эсийн шинэ мутацн бол гарсан. Энэ яг яах аргагүй энэ шинэ түлинээс хамааралтай байна. 2018 оноос бид нар энэ 5 улсын дэлхийн тийм ээ, Франц, Итали, мөн Сингапур, тэгээд ер нь дэлхийн эрүүл мэндийн 14 байгууллага хамтраад энэ баяжуулсан шахмал түлинээс гарч байгаа энэ утаанд дүн шинжилгээ хийгээд, зөвхөн

Монгол хүнд энэ элэгний шинэ төрлийн мутацид орсон вирус илэрлээ гэсэн энэ аймшигийн мэдээллийг бид нарт өгөөд байгаа.

Тэгэхээр энэ компани сая бол 44,6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж ... /минут дуусав/

С.Ганбаатар: Аудитын дүгнэлт хийсэн үү гэж асуулаа шүү. Тэр Тавантолгой түлшний асуудал ингээж хүндэрчхээд байхад аудитын дүгнэлт хийсэн үү. Хийсэн зөвлөмжийн дагуу ямар ажлууд хийсэн бэ гэж асуулаа.

Бусад холбогдох асуултуудыг та бүхэн хариулах байх. Ажлын хэсгийн 4 дүгээр ширээн дээр микрофон өгье.

Д.Загджав: Тавантолгой түлштэй холбоотой санхүүгийн аудитын дүнг бид нар бас хязгаарлалттай дүгнэлт өгөөд болох холбогдох материалыг хуулийн байгууллагад шилжүүлсэн байгаа.

С.Ганбаатар: Энхтуяа гишүүн тодруулъя.

Д.Энхтуяа: Нэгэнт аудитынхан ирсэн юм чинь түрүүнийхээ асуултыг дахиад давтчихъя. Энэ нийслэл дээр энэ хэрэгжиж байгаа томоохон төслүүд дээр урьд нь энэ дампуурчихсан гээд байгаа ерөөсөө татан буугдсан байгаа тэр эл ар ти, би ар ти, дүүжин тээвэр гээд энэ дээр та бүхэн бас аудит хийж үзсэн үү? Энэ асуудал нь ямар шатдаа байдаг юм бол оо?

С.Ганбаатар: Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Бид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд бол аудит хийж, энэ

нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар та бүхэнд танилцуулж байгаа. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа, нийслэлд хийгдэж байгаа энэ ажлууд дээр аудит хийгдээгүй байна. Тэгээд Монгол Улсын Ерөнхий аудитор бас энэ асуудлыг анхааралдаа авсан гэж ингээж бодож байна.

Түрүүний Тавантолгой түлш компанийн санхүүгийн тайланд аудит хийсэн. Хязгаарлалттай гэсэн санал, дүгнэлтийг өгсөн. Эрсдэлтэй бас нэлээдгүй асуудал байгаа. Санхүүгийн тайлангийн аудитаар Тавантолгой түлш компанийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийх зайлигүй шаардлага байгаа юм байна гэсэн ийм дүгнэлтийг бид гаргасан. Гаргасан тайлангаа бол холбогдох Байнгын хороодод хүргүүлсэн байгаа.

С.Ганбаатар: Гишүүдийн асуултад их тодорхой хариулаарай. Сая их тодорхой асууж байна шүү. Тавантолгой түлш. Тэр дүүжин тээвэр гээд олон том том алдагдалтай, луйврын маягтай зүйлүүд, одоо ногоон автобус шиг юмнууд л яваад байхад аудит энэ дээр дүгнэлтээ гаргаж хэлэх ёстой юм байна шүү. Үүнийгээ та нар бичгээр, тодорхой байдлаар Энхтуяа гишүүнд хүргэж өгөөрэй.

Одоо Энхтүвшин гишүүний асуултад түрүүн орж ирээгүй байна гээд хойшлуулсан. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн хариулна. 6 дугаар ширээнд.

Сангийн яам Тэлмүүн Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. 1 дүгээр асуултын хувьд хүү, торгуулийн орлогын задаргааг асуусан гэж ойлголоо.

Өнгөрсөн онд 2023 онд нийт 309 тэрбум төгрөгийн хүү торгуулийн орлого улс орон нутгийн бүх шатны төсөвт төвлөрсөн байгаа. Энд бол татвараас гадна бүх төрлийн Зөрчлийн тухай хуульд заасан бүх төрлийн торгуулийн

орлого бол ордог. Яг таны асуусан татварын байгууллагатай холбоотой орлогын шатлал сегментээрээ тоог нь бол яг бэлэн байхгүй учраас би танд татварын статистик баазаас шүүлгээж мэдээллийг өгье.

2 дахь асуултын хувьд, нүүрсний уул уурхайн бүтээгдэхүүний жишиг үнэ, биржийн арилжааны үнэтэй холбоотой асуултыг асуусан гэж ойлголоо.

Асуулт хариулахын өмнө эхлээд жишиг үнэ гэж Монгол Улсад бол байхгүй. Ашигт малтмалын хуулиар бол Монгол Улсын ашигт малтмалыг ашигласан тохиолдолд олон улсын зах зээлийн үнийг баримталж, олон улсын зах зээлийн үнээр АМНАТ-ыг тооцож авч байгаа.

Тэгэхээр жишиг үнэ гэдэг нь ингээд ярианы хэллэгт ингээд ороод явчихсан үнэ байгаа. Олон улсын зах зээлийн үнийн хувьд жишээ нь нүүрсэнд манайх Хятадын Эс экс колл гэдэг олон улсын худалдааны үнийг зарладаг үнийн эх сурвалжийг ашиглаж явдаг. Уул уурхайн биржээр төрийн болон орон нутгийн өмчит компаниуд бол заавал бүтээгдэхүүнээ арилжаалах хуулийн үүрэг хүлээсэн. Өнгөрсөн хугацаанд энд тодорхой үнийн зөрөө гарч байгаа. Тухайлах юм бол 2023 онд баяжуулсан нүүрсний хувьд 2 сараас 6 сарын хувьд бол дунджаар нэг 10 орчим хувийн үнийн зөрөөтэй байсан.

Зарим саруудад биржийн арилжааны үнэ нь Засгийн газраас зарлаж байгаа энэ жишиг гэж байгаа үнээс давсан тохиолдлууд бас байдаг. Тэгэхээр энэ бол бид нар тодорхой хугацааны явцад энэ үнийн зөрөө бол ингээд арилаад явна гэж үзэж байгаа.

Биржийн хэлцлийн үнэ бол яг хилийн цаад Гашиунсухайт боомт дээрх, Ганц мод боомт дээрх арилжааны үнийн нөгөө энкотерм нөхцөлөөр зарлагддаг, арилжаалагддаг. Олон улсын зах зээлийн

энэ эс экс коллын үнэ бол хилийн цаана тодорхой хэмжээний нэмүү өртөг шингээд Хятадын худалдан авагч талд гарч байгаа үнийн нөхцөлөөр зарлагддаг.

Тэгэхээр энэ дээр бол тодорхой хэмжээний инкотербийн нөхцөлийн зардлын үнийн зөрөө бол гарч байгаа. Энэ зардлын зөрөөг гаргах чиглэлээр Засгийн газар дээр ажиллаж байгаа. Өнгөрсөн 7 сард, өнгөрсөн 12 сард бас тодорхой энэ зардлын зөрөөг цэвэрлэх чиглэлээр бол ажлууд бол хийгдээд явж байгаа.

Яг таны асуусан биржийн үнэ, жишиг үнийн зөрөөгөөс орлогод орж төсвийн .../минут дуусав/

С.Ганбаатар: Тэлмүүн дарга хариулт хэллээ. 2 зүйл дээр Энхтүвшин гишүүнд нарийвчилж явуулья гэж ойлголоо.

Энхтүвшин гишүүн тодруулж, асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Тэгээд энэ 2 асуултын шалтгаан нь гэхээр зарим нэг ойлголтыг тодруулах тийм зорилготой, тэгээд жижиг, дунд аж ахуйн нэгжүүд татварын дарамт, хяналт шалгалт их байна гэдэгтэй холбоотой мэдээллийг энэ татвартай холбоотой, хүү, торгуультай холбоотой энэ татварын орлого нь аж ахуйн нэгжид ажилчдын тоогоор нь ямар байдалтай түүнийг илүү тодорхой болгох зорилготой бас байгаа.

2 дахь нь бас зарим нэг нөгөө боловсруулах үйлдвэрүүдийн хувьд бол давхар татвар ноогдууллаа. Ашигт малтмалын нөөц ашигласны татварыг бас бодит үнээс нь илүү тооцсоноос болоод үйл ажиллагаа явуулах эдийн засгийн хувьд бол боломжгүй боллоо гэдэг бас асуудлууд тавиад, зарим нь жишигээр дампуурлаа гэдэг байдал ярьж байгаа.

Тэгэхээр энэ ойлголтыг илүү тодорхой болгох үүднээс энэ түрүүн жишиг гэж би юу тэр олон улсын зах зээлийн үнэ нь ноогдуулж байгаа, татвар ноогдуулж байгаа үнэ нь биржид нь бирж илүү бодитой гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ үнийн зөрөөгөөсөө болж бас нөлөөлсөн юм болов уу гээд тэр эргэлзээг тайлах үүднээс ийм 2 тоо асууж байгаа шүү. Тэгээд дараа ... /минут дуусав/

С.Ганбаатар: Гишүүд, 1 дүгээр микрофон дээр, 1 дүгээр ширээн дээр ажлын хэсгийн 1 дүгээр ширээнд тодруулъя.

Д.Энхболд: Түрүүний Энхтуяа гишүүний асуусан асуулт дээр нэмэлт тодруулга хийх гэсэн юм. Тавантолгой түлш компани дээр тусгайлан аудит ороогүй. Эрдэнэс тавантолгой компанийн үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэлийн аудитаар тухайн Тавантолгой түлштэй холбоотой дараах асуудлууд гарсан байгаа. Үүнийг бас нэмэлт тодруулга байдлаар хэлчихье.

1-т нь, Эрдэнэс тавантолгой ХК 22 онд Тавантолгой түлш ХХК-тай санамж бичиг байгуулж, улмаар Эрдэнэс тавантолгой 2022/ 83 дугаартай баяжуулах болон коксжих коксын үйлдвэрийн барилга, байгууламж, бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн гэрээ нэртэй 113 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулсан нь ТЭЗҮ-д тусгасан хөрөнгө оруулалтын үнийн дүнгээс 3-4 дахин өндөр үнэтэй байна.

Эрдэнэс тавантолгой ХК-аас 23 онд ажлын хэсэг байгуулан Тавантолгой түлштэй 22 онд байгуулсан гэрээнүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээг дүгнэсэн боловч ажлын дагуу авч хэрэгжүүлсэн ажил хангалтгүй үр дүнгүй байна гэж үзсэн. Ерөнхий аудитороос Монгол Улсын Ерөнхий прокурорт шилжүүлсэн асуудал дээр Тавантолгой Түлш ХХК нь Эрдэнэс тавантолгой ХК-тай байгуулсан ЭТТ

2022/83, 2022/502, 2022/518 дугаар гэрээний дагуу авсан эргэн төлөгдөх урт хугацаатай хөрөнгийг Барилгын тухай хууль, барилгын норм дүрэмд заасан шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнд зориулалтын бусаар зарцуулах шийдвэр гарган, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан байж болзошгүй, улсад их хэмжээний хохирол учруулсан байж болзошгүй гэсэн үндэслэлээр хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байгаа. 1,1 их наядын дүнтэй ийм асуудал байгаа.

С.Ганбаатар: Энхтуяа гишүүн тодруулъя.

Д.Энхтуяа: Ер нь Аж үйлдвэржилтийн байнгын хорооны даргад бас хандаад хэлэхэд бид нар энэ Тавантолгой түлш дээр бас нэг очоод ажил байдалтай нь танилцах хэрэгтэй гэж бодож байна. Өнөөдөр бид нар дарга нар энд бид нар бие биедээ том том тоо хэлээд л ингээд суугаад байх биш. Цаана чинь үнэхээр аймгийн юм болж байгаа шүү дээ. Тэгээд бид нар бүгдээрээ л хохирогч болчихоод байна. Одоо бид нараас ямар өвчин, ямар хорт хавдрын ямар юу гарах нь ойлгомжгүй тийм ээ, бүрхэг байгаад байгаа.

Тэгэхээр нэг очиж, ажил байдалтай нь танилцаад, нийлээд нэг том тоо яриад суугаад байх биш нэг засаж залруулаад тийм ээ, хариуцлага тооцох ийм арга чарга байдаг юм уу л гэж бодож байна. Үнэхээр аймгийн газар байгаа шүү.

С.Ганбаатар: Энхтуяа гишүүн санал хэллээ.

Нарийн яривал Аудитын ерөнхий газар бол өнгөрсөн 4 жил, миний ойлгосноор маш сайн ажилласан. Улсын Их Хурлын гишүүдийн нүд, чих болж, Их Хурлаас томилогддог байгууллага шүү дээ. Ажилласан. Тэндээс гарч байгаа зөвлөмж, шийдвэрүүдийг харин хэрэгжүүлэх тал дээр Их Хурлын гишүүд

шахаж, шаардаж ажиллах ёстой гэж би ойлгодог, үздэг.

Ингээд хойшид Улсын Их Хурлын гишүүд болон холбогдох яамнууд аудитын дүгнэлтээ зүгээр нэг жилдээ нэг 2 удаа ингээд сонсоод, сонссон болоод салдаг биш яг тэр зөвлөмжийг хэрэгжүүлдэг, араас нь хөөцөлддөг, нягталдаг байх ёстой гэдэг энэ байр суурийг би илэрхийлээд Улсын Их Хурлын гишүүд Аж үйлдвэржилтийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд асуулт асууж, хариулт авлаа.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон аудитын дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?

Очирбат гишүүнээр тасаллаа. Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ.

Д.Үүрийнтуяа: Ер нь бид нар энэ улсын тухайн оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг чуулганаар оруулаад эхний хэлэлцүүлэг, 2 дахь хэлэлцүүлэг Байнгын хороод, салбар салбарын Байнгын хороод хэлэлцэж байгаагийн ач холбогдол нь өөрөө энэ Байнгын хороодод харьяалагдаж байгаа төрийн захиргааны төв байгууллагууд буюу яамдын асуудлууд энэ нэгтгэсэн тайлан нэгдсэн төсөвт хэрхэн ямар үр дүн үзүүлээд байгаа юм бэ гэдгийг л бас хэлэлцэж, ярилцаж, шүүж, санал, дүгнэлтээ гаргах ёстой байх л даа.

Тэгээд өнөөдөр бол Байнгын хорооны гишүүдэд яг энэ чиглэлийн мэдээллүүд бол бас их дутмаг байна. Бид нар нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн нэгдсэн дүгнэлтүүдийг, аудитын мөн нэгдсэн дүгнэлтүүдийг аваад, үүн дотроосоо манай Байнгын хороонд харьяалагдаж байгаа яамдын асуудал хаана, хэрхэн, яаж тусаж вэ гэдгийг тухайлбал гэдэг үгээр л харж байгаа юм. Тухайлбал гээд жишээ аваад татчихсан

яамдын асуудлыг л харж байна гэсэн үг. Тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд орчихсон байгаа ажлыг тухайн жилийн санхүүжилтийн дүнгээр нь л тайлагнаж оруулж ирж байна. Гэтэл өмнөх тэр төлөвлөсөн ажил нь хэдэн онд эхлээд, хэзээ дуусах ёстой ажил нь дуусахгүй үргэлжлээд, ямар шалтгаан нөхцөл байгаа юм гэдэг юм харагдахгүй. Нийт дүнгээрээ ч санхүүжилтийн гүйцэтгэл нөгөө талдаа ажлын гүйцэтгэлд зөрөөтэй юү гэдэг нь ч тодорхойгүй.

Нөгөө төсвийн ерөнхийлөн захирагчид аудит ямар дүгнэлт өгөөд, ямар асуудлууд байгаа юм бэ гэдэг нь ч мэдэгдэхгүй өнөөдөр Байнгын хорооны хурлаар л бид нар энэ асуудлыг хэлэлцээд сууж байна шүү дээ.

Тийм болохоор цаашдаа энэ мэдээ мэдээллүүд дээр илүү яг Байнгын хороонд харьяалагдаж байгаа энэ төсвийн ерөнхийлөн захирагчдын асуудлыг их тодорхой оруулдаг байх асуудлыг хаа хаанаа анхаармаар байна.

Тэгээд ялангуяа яамнууд маань мэдээлэлд энэ хариултууд өгөхдөө бас тодорхой хэлмээр байна. Шаардлагатай бол энэ асуудлууд дээр бас нэмэлт мэдээ, мэдээллүүдийг давхар гаргаж өгдөг баймаар байна. Тэгээд иймэрхүү байдлаар хэдүүлээ нэг ерөнхий мэдээлэлтэй хэлэлцсэн болоод ингээд суух юм бас үр дүн багатай л санагдаж байна.

С.Ганбаатар: Энхтүвшин гишүүн үг хэлнэ.

Д.Энхтүвшин: Би бусад Байнгын хороон дээр бас асуугаад, хариулт авч чадаагүй зүйлээ бас энд хэлчихье. Нөгөө Тэлмэн энэ тэр бас байгаагүй учраас.

1 дүгээрт болохоор энэ нөгөө бид нар Төсвийн тогтвортой байдлын хуулиар зарим хязгаарлалтууд байгаа. Тэгэхээр уул уурхайн бус салбарын

өсөлттэй холбоотой хязгаарлалт байгаа. Тэгэхээр энэ дээр болохоор дотоодын эдийн засгийн өсөлт 7 хувиар өссөн гэж байгаа. Тэгэхдээ энэ дотор тээвэр агуулахын салбарыг уул уурхайн өсөлттэй идэвхжилттэй холбоотойгоор тээврийн салбар өссөн ийм үзүүлэлтүүд байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл зарим нөхцөлийг нь болохоор уурхайн ам нөхцөлөөр ч юм уу тээврийг нь салгаад тусдаа оруулчихсан юм шигээр, зарим нь болохоор хил нөхцөлөөр буюу тээвэр нь орчихсон үнээр явж байгаа юм шиг.

Тэгэхээр энэ дээр энэ 1,8 хувийн эдийн засгийн өсөлт гэдэг дээр тээвэртэй холбоотой, ул уурхайн тээвэртэй холбоотой өсөлт нь хэдэн хувь байв, байгаа вэ? Үүнийг өөрчилж тооцвол тэр дотоодын нэг уулын уурхайн бус салбарын өсөлттэй холбоотой хязгаарлалтууд яаж өөрчлөгдөх вэ гэдэг тийм асуулт тавьсан. Гэхдээ хариулт авч чадаагүй.

Тэгээд нэлээн тулгасан. 23,3 хувийн уулын уурхайн бус өсөлттэй гээд төсвийн зардлын тэлэлт болохоор 23,2 гэсэн байгаа. Тэгэхээр энэ өөрчлөлтийг оруулбал нэлээн шахуу, бараг энэ төсвийн тогтвортой байдлын хууль зөрчсөн байдлаар харагдах гээд байгаа. Ийм нэг асуулт тавьсан. Энэ дээр бас нэгдсэн чуулганаас өмнө хариулт авмаар байна.

2 дугаарт болохоор энэ татварын орлогууд бас нэмэгдсэн байгаа. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлүүд. Тэгэхээр яах вэ, аж ахуйн нэгжүүдийн хувьд байдал бас амаргүй байгаа. Тэгэхээр энэ дээр төрийн оролцоотой болон ТӨК-ууд, уул уурхайн салбаруудтай хамааралтай компаниудын жишээлбэл орлогын албан татварын өсөлт, НДШ-ийн өсөлтүүд нь ямар вэ гэдэг мэдээлэл авъя гэсэн ийм хүсэлт байсан. Тэгээд энэ хариултаа авч чадаагүй байгаа.

Тэгээд өөр чинь, тийм нэг асуудал болохоор яг энэ бэлдсэн материал бас шаардлага хангахгүй байна лээ. Ялангуяа төсвийн тухай ойлголтууд нэлээн нэгхэн үгэн дээр зөрж байгаа. Тэр энэ ойлголтуудыг бэлдсэн танилцуулга дээр алдаатай бичсэн байна лээ.

Улсын төсөв, нэгдсэн төсөв гэдгийг хооронд нь хольж солиод тэгээд 1 ижилхэн, эхлээд эхлээд уншаад явж байсан чинь нэгдсэн төсөв юм уу гэсэн чинь, тэр нь болохоор зүгээр улсын төсөв болж таараад, тэгээд хойно задаргаа дээр болохоор өөр дүнтэй. Тэгээд уул нь нэгдсэн төсөв дээр чинь орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сангийн сангуудын юу орохгүй байтал хойно задаргаа дээр оруулаад биччихсэн.

Тэгэхээр ийм хоорондоо уялдаагүй заалтууд байсан учраас үүнийгээ цаашид бас анхаарна биз ээ. Тэнд уул нь энэ чинь 6 сард бэлдсэн гэж ойлгосон. Тэгэхээр 1 их яаралтай ч юм уу, яаруу сандруу биш биз байсан учраас ялангуяа энэ нөгөө шинэ гишүүд их байгаа учраас энэ төсөвтэй холбоотой нэгдсэн төсөв болон улсын төсөв гэдэг ийм маш зөрөөтэй ойлголт дээр 2 өөр тоо яваад байхаар үүнийгээ бас залруулахгүй бол цаашид анхаарна биз ээ гэж хэлмээр байна.

С.Ганбаатар: Аудитын ерөнхий газар материалыг ч би чинь ер нь их л уншдаг хүн дээ. Тийм алдаа гайгүй байх шиг байсан. Зүгээр та нар, тэгэхдээ гишүүнд бас нарийвчилж тайлбарлах ёстой шүү бас гишүүн нарийн юм харсан байх талтай. Тэгээд та нар уулзаарай.

Засгаас өргөн барьсан танилцуулга дээр гэж байна шүү. Түүнээс аудитыг бол түүн дээр бол юм байхгүй байсан санагдаж байна.

Золжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Золжаргал: Энэ нэг жижигхэн юм шиг мөртөө сонирхолтой бөгөөд

чухал нэг асуудал байна л даа. Норматив зардал гээд нэг ангилал байгаа. Юуны нөгөө хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн зардлын задаргаа дээр болохоор 22 сая төгрөг гээд уул уурхай, хүнд үйлдвэрийн зардлын задаргаа дээр болохоор 1 сая төгрөг гэгчихсэн. Тэгээд би энэ миний мэдэхийн энэ байнга л хөдөө, гадаа явж байдаг төсөл, төлөвлөгөө шалгалт хяналт гээд л явдаг хүмүүс. Тэгээд 1 сая төгрөгийн нормын хувцас гэдэг чинь 10 гутал, гайгүй юм хэрэглэе гэвэл нэг 3 гутлын үнэ л дээ. Тэгээд энэ энэ танилцуулга дээр алдаатай бол бичээгүй байлгүй дээ. 1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан, төлөвлөгөө нь болохоор 3,4 сая гэсэн юм байна. Тэгээд байнга яах вэ, төсөв зардал хэмнэлгүй л яах вэ. Тэгэхдээ ийм ганц 2 сая төгрөгийн норм, энэ чинь хүний эрүүл мэндтэй холбоотой байнга хөдөө гадаа явж байдаг хүмүүс аж үйлдвэрлэл, эрдэс баялгийн шинэ дараа жилийнхээ төсөвт та бүхэн маань үүнийг анхаарна биз дээ гэж хэлье дээ. Баярлалаа.

С.Ганбаатар: Энэ дээр. Очирбат гишүүн түрүүн бас яаралтай хуралтай байна гээд гараад явсан.

Тэр үнэхээр Золжаргал гишүүний бас үнэн байна шүү. Үүнийг нягталж та бүхэн бас хараарай.

Ингээд гишүүд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон аудитын дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцсэн талаарх Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг гишүүн танилцуулна.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Ингээд оролцсон ажлын хэсгийн нөхдөдөө, гишүүддээ баярлалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ